



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 27-ны өдөр

Дугаар A/111

Эрдэнэт

“Коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын үед хэрэглэх “Ремдесивир 100мг №1” вирусын эсрэг эм, тоног төхөөрөмжийн хуваарь батлах тухай”

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 сарын 18-ны “тоног төхөөрөмж хуваарилах тухай” А/610 тоот тушаал, 2021 оны 10 дүгээр сарын 19-ны өдрийн “Эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед шаардлагатай эмийн хуваарилалт”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын бэлэн байдлыг хангах, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмчилгээг үр дүнтэй байлгах ажлын хүрээнд Эрүүл мэндийн яамнаас нийлүүлэгдсэн Ремдесивир 100мг №1 вирусын эсрэг эм, тоног төхөөрөмж олгох хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Коронавируст халдвар /ковид-19/ цар тахалд хэрэглэх Ремдесивир 100мг №1 вирусын эсрэг эмийн чанар, хадгалалт, зарцуулалт, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т, хавсралтын дагуу байгууллагад олгох, анхан шатны бүртгэлийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын нярав /Б.Алтанзагас/ нарт үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу олгосон Ремдесивир 100мг №1 вирусын эсрэг эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалт, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга /Ц.Наран-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 10 сарын 27 өдрийн
10/11 дугаар тушаалын хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/ ЦАР ТАХЛЫН ҮЕД ХӨРӨГЛӨХ
“РЕМДЕСИВИР 100МГ №1” ВИРУСЫН ЭСРЭГ ЭМИЙН ХУВААРИЛАЛТ

№	Эрүүл мэндийн байгууллагуудын нэр	Бүсийн оношилгоо эмчилгээний төв		
		Тоо хэмжээ /ширхэг/	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Ремдесивир 100мг №1 /тарилгын нунтаг/	1,000	45,453.81	45,453,810
2	Өвчтөн хянах монитор EDAN IM60 /дагалдах хэрэгслийн хамт/	1	4,596,426	4,596,426
Нийт		1,001		50,050,236